МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 27 өдөр Дугаар А/26 Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежоос бусад боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагыг хуульд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцох журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэхэд нэгдсэн арга зүй, удирдамжаар ханган ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яамны дэргэдэх салбар зөвлөл (Х.Батжаргал)-д зөвлөсүгэй.

3. Журам батлагдсантай холбоотойгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай” А/182 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД П.НАРАНБАЯР

АТА12937 9116621 9024070582

1426010074

Боловсролын сайдын 2026 оны 01.. дүгээр сарын 27. –ний өдрийн А/26. дугаар тушаалын хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖООС БУСАД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН РЕКТОР, ЗАХИРАЛ, ЭРХЛЭГЧИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИХ ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХУУЛЬД ЗААСАН БАЙГУУЛЛАГАД АЖИЛЛАСАН ЖИЛТЭЙ ДҮЙЦҮҮЛЭН ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсролын ерөнхий хуулийн 33.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежоос бусад боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал, эрхлэгчийн албан тушаалд тавих тусгай шаардлагад заасан хугацааг Боловсролын ерөнхий хуулийн 17.1 дэх хэсэг, 25, 28 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцоход энэхүү журмыг баримтална.

1.2. Иргэн Төрийн албаны тухай хуулийн 33.2.2-т заасан тусгай шалгалт өгөх, "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх сонгон шалгаруулалтын журам"-ын 2.1.3.2-т заасан сонгон шалгаруулалтад оролцоход ажилласан жилийг энэ журамд зааснаар дүйцүүлэн тооцно.

1.3. Иргэн энэхүү журмын 1.1-т заасан байгууллагад ажилласан жилээ дүйцүүлэн тооцуулснаар тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох эрх үүснэ.

Хоёр. Ажилласан жилд дүйцүүлэн тооцох хугацаа

2.1. Энэхүү журмын 1.1-д заасан албан тушаалд ажилласан жилийг дор дурдсанаар дүйцүүлэн тооцно:

№	Албан тушаал	Ажилласан жил		
		Боловсролын сургалтын байгууллагад ажилласан 1 жил тутам	Боловсролын сургалтын байгууллагад багшаар ажилласан 1 жил тутам	Тэнхимийн эрхлэгч, албаны дарга, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйчээр ажилласан 1 жил тутам
1	Удирдах албан тушаалд	1 жил	1 жил	1 жил
2	Гүйцэтгэх албан тушаалд	1 жил	1 жил	50 хувиар тооцно

2.2. Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан байгууллагад ажилласан жилтэй дүйцүүлэн тооцоход энэхүү журмыг баримталж болно.

2.3. Иргэний Боловсролын ерөнхий хууль, энэхүү журам батлагдахаас өмнөх хугацаанд томилогдсон, өөрөөс үл хамаарах шалтгаанаар сул орон тоог зарлагдаагүйгээс хамаарч ажиллаж байгаа боловсролын сургалтын байгууллагад захирал, сургалтын менежер, эрхлэгч, арга зүйчийн ажилласан 1 жилийг

боловсролын сургалтын байгууллагад багшаар ажилласан 1 жилтэй тус дүйцүүлэн тооцож болно.

Гурав. Бусад

3.1. Журмын 1.1-д заасан байгууллагад ажилласан жилийг дүйцүүлэн тооцох бичиг баримт хуурамчаар бүрдүүлсэн, бичиг баримт бүрдүүлэхэд тусалсан, бусдад давуу байдал олгосон албан тушаалтан, иргэнд Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

---000---